

# МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2009 оны 03 дугаар  
сарын 04-ны өдөр

Дугаар 125/60

Улаанбаатар  
хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Банкны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 459/207 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ийн 2 дугаар бүлэгт дор дурдсан агуулга бүхий 14 дэх хэсэг нэмсүгэй.

1/журмын 2.14 дэх хэсэг:

“14.Зээлийн гэрээний хугацаа 1 удаа сунгагдсан бол зээлийн ангиллыг хэвээр үлдээж болно. Харин зээлийн гэрээний хугацааг 2 дахь удаагаа сунгаж байгаа тохиолдолд зээлийн ангиллыг нэг шатлалаар бууруулна.”

2.Мөн журмын 2.11 дэх хэсгийн “1 удаа” гэснийг “2 удаа” гэж, 3.2 дахь хэсгийн “40 хувь” гэснийг “25 хувь” гэж, “75 хувь” гэснийг “50 хувь” гэж, “1а хавсралтын”-ын “Зээл болон хүлээж болзошгүй үүргийн хугацааны үзүүлэлтийг дүгнэх хүснэгт”-ийн “181-270 хоног” гэснийг “181-360” гэж, “271-ээс дээш” гэснийг “361-ээс дээш” гэж тус тус өөрчилсүгэй.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Хяналт шалгалтын газар (Ж.Ганбаатар)-т, Сангийн яамны Санхүүгийн бодлого, зохицуулалтын газар (Б.Батбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

